



**ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**



## Агуулга

|       |   |    |
|-------|---|----|
| 1     | Аудитын гэрчилгээ .....   | 2  |
| 2     | Аудитын тайлан .....  | 4  |
| 2.1   | Оршил .....   | 4  |
| 2.2   | Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....   | 4  |
| 2.3   | Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....  | 5  |
| 2.4   | Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....  | 5  |
| 2.5   | Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ..... | 6  |
| 2.6   | Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....   | 6  |
| 2.7   | Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....  | 7  |
| 2.8   | Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....   | 7  |
| 2.8.1 | Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл: .....                                  | 8  |
| 2.8.2 | Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар .....     | 8  |
| 2.8.3 | Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар .....                  | 9  |
| 2.9   | Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....                                  | 9  |
| 2.10  | Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....   | 9  |
| 2.11  | Шилэн дансны мэдээлэл .....   | 10 |
| 2.12  | Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....  | 10 |
| 2.13  | Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....   | 10 |
| 3     | Менежментийн захидал .....  | 11 |
| 3.1   | Санхүүгийн түрээсийн гэрээтэй холбоотой асуудал .....   | 11 |
| 3.2   | "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг тооцох, санхүүжүүлэх журам"-тай холбоотой асуудал .....  | 12 |
| 3.3   | Авлагатай холбоотой асуудал .....   | 12 |
| 3.4   | Шатахууны тооцоотой холбоотой асуудал .....   | 13 |
| 3.5   | Малын үнийг шинэчлэн тогтоох талаар .....   | 13 |
| 4     | Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....                            | 15 |
| 4.1   | Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....  | 15 |
| 4.2   | Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....   | 16 |
| 4.3   | Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....   | 17 |
| 4.4   | Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....  | 18 |
| 4.5   | Аудит хийсэн жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....   | 19 |
| 5     | Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....   | 22 |

## Товчилсон үгийн жагсаалт

|          |   |
|----------|---|
| АДБОУС   | Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт            |
| АОУС     | Аудитын Олон Улсын Стандарт                                 |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА  
С.БААТАРЖАВ ТАНАА

2019.03.25 № 01/562  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Цагдаагийн ерөнхий газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Цагдаагийн ерөнхий газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Цагдаагийн ерөнхий газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



## Үүрэг хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С О Ю У Н Б И Л Э Г



## **2 Аудитын тайлан**

### **2.1 Оршил**

Цагдаагийн ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч, Цагдаагийн хурандаа С.Баатаржав Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн авлагыг барагдуулах, шатахууны үлдэгдлийн тооцоог хийж зөрүүгүй тохируулах, малын үнийг шинэчлэн тогтоох, хохирол тооцох, үнэлгээ, шинжилгээ хийж дүгнэлт гаргуулах зардлын хэмжээг холбогдох хууль, журамд нийцүүлэн нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулж, шийдвэрлүүлэх, мөн төлөвлөгөөнд тусгагдаагүй, холбогдох байгууллагын зөвшөөрөлгүй Санхүүгийн түрээсийн гэрээ байгуулахгүй байх зэрэг зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Цагдаагийн ерөнхий газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагдаагийн ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 3 дугаар сарын 5-наас 2019 оны 3 дугаар сарын 19-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, УАГ-ын Санхүүгийн аудитын газрын аудитор О.Баярмаа, гэрээт аудитор Ш.Гүрпүрэв нар гүйцэтгэв.

Цагдаагийн ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 01/133 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.



### **2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

### **2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Цагдаагийн ерөнхий газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Цагдаагийн ерөнхий газар нь “Ажил үйлчилгээ нь нийгмийн хөгжлийн эрэлт хэрэгцээ шаардлагад бүрэн нийцсэн амар тайван амьдралын баталгааг хангасан тэргүүлэх байгууллага болох” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Цагдаагийн ерөнхий газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлон зорилтуудыг дэвшүүлэн, хэрэгжилтийг нь хангаж ажилласан байна. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх,
- Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх,
- Үндсэн чиг үүргийн хүрээнд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын чанар, үр дүнг дээшлүүлэх,
- Цагдаагийн байгууллага, албан хаагчийн эрх зүйн орчныг шинэчилж, сургалтын үр нөлөөг дээшлүүлэх,
- Албан хаагчдын ажлын хариуцлага, харилцааны соёл, ёс зүйн шаардлагыг хангаж ажиллах зорилт дэвшүүлэн, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажилласан байна.

Цагдаагийн ерөнхий газрын удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль



- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Цагдаагийн албаны тухай хууль
- Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Цагдаагийн ерөнхий газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Цагдаагийн ерөнхий газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд аудитад мэдээллийн технологийн мэргэжилтэн татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Цагдаагийн ерөнхий газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Цагдаагийн ерөнхий газрын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Цагдаагийн ерөнхий газрын дотоод аудитын алба 3 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд, мөн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2 удаа хяналт шалгалт хийжээ. Аудитаар нийт 25 асуудалтай холбогдуулан 69 заалттай зөвлөмж хүргүүлснээс, хэрэгжилтийг 93.3 хувьтай биелүүлсэн байна.

## **2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Цагдаагийн ерөнхий газрын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 17 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 17 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.



Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## 2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Энэ нь нийт орлогын 76.3 хувь нь улсын төсвийн санхүүжилтээс бүрддэг, нийт зардлын 87.5 хувийг бараа, ажил үйлчилгээний зардал эзэлж байгаа тул зардлын гүйлгээ эрсдэлтэй гэж үзсэнтэй холбоотой юм.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшинг Цагдаагийн ерөнхий газрын 2018 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 219,385.6 сая төгрөгийн 1 хувь буюу 2,193.8 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлээр төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшинг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

## 2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд эрхлэх асуудлын хүрээний 62 төсвийн байгууллагын, 1 ТӨҮГ-ын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс, нийт 62 байгууллага аудитад хамрагдсан байна.

Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

| № | Байгууллагын ангилал   | Санал дүгнэлт гаргасан | Аудитын түүвэрт хамрагдсан | Итгэл үзүүлсэн | Аудитад хамрагдаагүй |
|---|--|------------------------|----------------------------|----------------|----------------------|
| 1 | Орон нутгийн Цагдаагийн байгууллагууд                        | 18                     |                            | 7              |                      |
| 2 | Нийлэлийн цагдаагийн газар болон түүний харьяа байгууллагууд | 18                     |                            |                |                      |
| 3 | Төрийн өмчит үйлдвэрийн газар                                | 1                      |                            |                |                      |
| 4 | ЦЕГ болон түүний шууд харьяа байгууллагууд                   | 1                      | 16                         |                | 1                    |
|   | <b>Дүн</b>   | <b>38</b>              | <b>16</b>                  | <b>7</b>       | <b>1</b>             |

Аудитаар төсвийн 37 байгууллагын санхүүгийн тайланд санал дүгнэлт гаргаснаас бүх байгууллагад “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна. “Цагаан шонхор ТӨҮГ”-т гэрээгээр Өлзийт Экаунт Аудит ХХК аудитыг гүйцэтгэн “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.





### 2.8.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Цагдаагийн ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 1,629.8 сая төгрөгийн 154 алдаа, зөрчил илрүүлснээс 65.0 хувь буюу 1,059.7 сая төгрөгийн 33 алдааг аудитын явцад залруулж, 0.3 хувь буюу 5.5 сая төгрөгийн зөрчилд 9 төлбөрийн акт тогтоож, 11.1 хувь буюу 181.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 35 албан шаардлага өгч, 23.6 хувь буюу 383.5 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 77 зөвлөмжийг хүргүүлээ.

Аудитаар төсвийн шууд захирагчийн хэмжээнд 534.0 сая, төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээнд 525.7 сая төгрөгийн алдааг тус тус залруулсан байна.

Цагдаагийн ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчил түүний шийдвэрлэлтийг дараах хүснэгтээр нэгтгэн үзүүлэв.

(сая төгрөг)

| № | Байгууллагын ангилал   | Залруулаагүй алдаа, зөрчил |              | Үүнээс:       |            |                 |              |           |              |                            |          |  |          |
|---|--|----------------------------|--------------|---------------|------------|-----------------|--------------|-----------|--------------|----------------------------|----------|--|----------|
|   |  |                            |              | Төлбөрийн акт |            | Албан шаардлага |              | Зөвлөмж   |              | Хариуцлага тооцуулах санал |          | Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн |          |
|   |  |                            |              | Тоо           | Дүн        | Тоо             | Дүн          | Тоо       | Дүн          | Тоо                        | Дүн      | Тоо                                    | Дүн      |
| 1 | Орон нутгийн Цагдаагийн байгууллагууд                        | 27                         | 89.7         | 4             | 4.0        | 3               | 30.1         | 20        | 55.6         | -                          | -        | -                                      | -        |
| 2 | Нийлэлийн цагдаагийн газар болон түүний харьяа байгууллагууд | 70                         | 287.7        | 5             | 1.6        | 30              | 149.1        | 35        | 137.0        | -                          | -        | -                                      | -        |
| 3 | Төрийн өмчит үйлдвэрийн газар                                | 3                          | 10.0         | -             | -          | 1               | 1.9          | 2         | 8.1          | -                          | -        | -                                      | -        |
| 4 | ЦЕГ-ын шууд харьяа байгууллагууд                             | 18                         | 182.7        | -             | -          | 1               | -            | 17        | 182.7        | -                          | -        | -                                      | -        |
| 5 | Төсвийн төвлөрүүлэн захирагч                                 | 3                          | -            | -             | -          | -               | -            | 3         | -            | -                          | -        | -                                      | -        |
|   | <b>Дүн</b>   | <b>121</b>                 | <b>570.1</b> | <b>9</b>      | <b>5.6</b> | <b>35</b>       | <b>181.1</b> | <b>77</b> | <b>383.4</b> | <b>-</b>                   | <b>-</b> | <b>-</b>                               | <b>-</b> |

### 2.8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар

Цагдаагийн ерөнхий газрын харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлсэн алдаа зөрчлийг тоймлон харуулбал:

1. Орон нутаг дахь Цагдаагийн байгууллагуудад нийт 91.5 сая төгрөгийн 31 алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 1.8 сая төгрөгийн 4 алдааг залруулж, залруулагдаагүй 4.0 сая төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 30.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага, 55.6 сая төгрөгийн алдааг засах 20 зөвлөмж өгсөн,
2. Нийлэлийн цагдаагийн газар болон түүний харьяа байгууллагуудад нийт 819.9 сая төгрөгийн 93 алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 532.2 сая төгрөгийн 23 алдааг залруулж, залруулагдаагүй 1.6 сая төгрөгийн зөрчилд 5 төлбөрийн акт тогтоож, 149.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 30 албан шаардлага, 137.0 сая төгрөгийн алдааг засах 35 зөвлөмж өгсөн,



3. Төрийн өмчит үйлдвэрийн газарт нийт 535.7 сая төгрөгийн 9 алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 525.7 сая төгрөгийн 6 алдааг залруулж, залруулагдаагүй 1.9 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 8.1 сая төгрөгийн алдааг засах 2 зөвлөмж өгсөн,
4. ЦЕГ-ын шууд харьяа байгууллагуудад нийт 182.7 сая төгрөгийн 18 алдаа зөрчил илэрснээс 1 албан шаардлага, 182.7 сая төгрөгийн алдааг засах 17 зөвлөмж өгсөн.

### **2.8.3 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлсэн горим сорилын гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 17 чиглэлээр 17 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцохоор шийдвэрлэлээ.

Аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд тусгасан ба бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал илрээгүй байна.

### **2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал илрээгүй болно.

### **2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Цагдаагийн ерөнхий газарт нийт 185,427.9 сая төгрөгийн төсөв зарцуулахаар батлагдсанаас 154,437.1 сая төгрөгийг бараа, ажил үйлчилгээний зардал, 11,089.8 сая төгрөгийг урсгал шилжүүлэг, 19,901.0 сая төгрөгийг хөрөнгийн зардал тус тус эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Тайлант онд Цагдаагийн ерөнхий газарт нийт 185,427.9 сая төгрөгийн төсөв зарцуулахаар батлагдсанаас 176,345.9 сая төгрөгийг улсын төсвөөс, 120.4 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 8,961.6 сая төгрөгийг Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Зардлын гүйцэтгэлээр нийт 329.7 сая төгрөг буюу 0.2 хувийн хэмнэлттэй байгаа нь тайлант онд тэтгэвэрт гарсан алба хаагчийн ажлын байранд нөхөн томилох хүртэл хугацааны цалингийн зардал, зарим салбар хэлтэс нэгдсэн халаалтанд холбогдсон, 6 байгууллагын орлогын төлөвлөгөө биелээгүй тул зардал гаргаагүй зэргээс шалтгаалжээ.

Нэмэлт санхүүжилтээр тайлант онд 7,363.5 сая төгрөгийг хүлээн авсанаас дээд шатны төсвийн захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 5,359.5 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны



хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,243.2 сая төгрөг, орон нутгийн Засаг даргын нөөц сангаас хуваарилсан хөрөнгө 501.6 сая төгрөг, НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөрийн төслийн санхүүжилт 259.2 сая төгрөгийг тус тус эзэлж байна. Нэмэлт санхүүжилтээс бараа ажил, үйлчилгээний зардалд 7,048.9 сая, урсгал шилжүүлэгт 174.4 сая, хөрөнгийн зардалд 343.2 сая, нийт 7,566.5 сая төгрөгийг зарцуулж, зарцуулагдаагүй 106.6 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

## **2.11 Шилэн дансны мэдээлэл**

Цагдаагийн ерөнхий газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

“Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитаар тус байгууллагад хуулийн хэрэгжилт “хангалттай” гэж үнэлсэн ба шаардлагатай мэдээллийг shilendans.mn цахим хуудсанд бүрэн оруулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## **2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар нийт 659.3 сая төгрөгийн 112 алдаа, зөрчил илэрсэн ба залруулагдаагүй 9.8 сая төгрөгийн зөрчилд 9 төлбөрийн акт, 58.8 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага, 590.7 сая төгрөгийн алдааг залруулах 98 зөвлөмж өгсөн байна. Үүнээс төлбөрийн акт болон албан шаардлагыг 100 хувь биелүүлж, зөвлөмжийн биелэлт 98.9 хувьтай байна.

Зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримтаар баталгаажуулж, гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

## **2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Цагдаагийн ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Цагдаагийн ерөнхий газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.



### **3 Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Цагдаагийн ерөнхий газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Санхүүгийн түрээсийн гэрээтэй холбоотой асуудал**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

ЦЕГ-ын дарга, Ди Би Эм Лизинг ХХК-ийн гүйцэтгэх захирал нарын 2018 оны 7 дугаар сарын 5-ны өдөр СТГ-18/15/2018/VII/25/76 дугаартай Санхүүгийн түрээсийн гэрээг байгуулсан байна. Тус гэрээнд Ази европын дээд түвшний 11 дүгээр уулзалтын үйл ажиллагаанд ашиглаж байсан Солонгос улсад үйлдвэрлэсэн "Hyundaiuniverse luxuri" загварын 45 хүний суудалтай 5 ширхэг автобусыг санхүүгийн түрээсийн гэрээгээр ашиглаж, 1,350.0 сая төгрөгийг 10 жилийн хугацаатай, жилийн 4.5 хувийн хүүтэй, жилд 2 удаа буюу 1, 7 дугаар саруудад нийт 169.1 сая төгрөгийг төлөхөөр, түрээслэгч түрээсийн төлбөрийг түрээслүүлэгчид төлөх гэрээний үүрэг бүрэн биелэгдсэн үед өмчлөх эрхийг шилжүүлэхээр тусгасан байна. Мөн төсөв, төлөвлөгөөнд тусгагдаагүй, хөрөнгийн эх үүсвэргүй, ТӨБЗГ-ын зөвшөөрөлгүйгээр "Санхүүгийн түрээсийн гэрээ"-г байгуулсан байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2.4-т "... үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх, устгах саналаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах." гэж заасантай нийцэхгүй байна.

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**



ТӨБЗГ-ын зөвшөөрөлгүй, төлөвлөгөөнд тусгагдаагүй, хөрөнгийн эх үүсвэргүйгээр Санхүүгийн түрээсийн гэрээ байгуулахгүй байх, холбогдох хууль, тогтоомжийг мөрдөж ажиллах

#### 3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Үйлчлүүлэгч байгууллага асуудлыг хүлээн зөвшөөрч асуудлын бүртгэлд гарын үсэг зурж баталгаажуулсан.

### **3.2 "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг тооцох, санхүүжүүлэх журам"-тай холбоотой асуудал**

#### 3.2.1 Илрүүлэлт:

Засгийн газрын 2018 оны 161 дүгээр тогтоолоор батлагдсан "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг тооцох, санхүүжүүлэх журам"-д аудит, эдийн засаг, байгаль орчны хохирол тооцох, шинжилгээ хийж дүгнэлт гаргах, эд хөрөнгийн үнэлгээ хийлгэхэд гарах зардлын хэмжээг нарийвчлан тогтоогоогүй, гарсан зардлыг тухайн үйл ажиллагааны үйлчилгээний хөлсний хэмжээгээр олгохоор заасан байна.

#### 3.2.2 Эрсдэл:

Дээрх журамд аудит, эдийн засаг, байгаль орчны хохирол тооцох, шинжилгээ хийж дүгнэлт гаргах, эд хөрөнгийн үнэлгээ хийлгэхэд гарах зардлын хэмжээг нарийвчлан тогтоогоогүйгээс төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах эрсдэлтэй

#### 3.2.3 Өгсөн зөвлөмж:

Холбогдох хууль, журамд нийцүүлэн судалгаанд үндэслэн аудит, эдийн засаг, байгаль орчны хохирол тооцох, шинжилгээ хийж дүгнэлт гаргах, эд хөрөнгийн үнэлгээ хийлгэхэд гарах зардлын хэмжээг нарийвчлан тогтоох талаар санал боловсруулж, журамд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг шийдвэрлүүлэх

#### 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

